

ГАРЫН АВЛАГА

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУДАЙ
НИЙЦСЭН БОНДЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
ХАНГАСАН ЗАРДАЛ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ
ҮНЭЛЭХ, СОНГОХ**

*Энэхүү гарын авлагыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй
“Хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг дэмжих” техникийн туслалцааны төслийн
“Тогтвортой Хөгжлийн Зорилгын үр нөлөөний хэмжилт, тайлагнал” дэд төслийн хүрээнд
Сангийн яам, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөртөй хамтран боловсруулав.*

Энэхүү зөвлөхийн тайлан нь АХБ эсвэл холбогдох Засгийн газрын байр суурийг илэрхийлэхгүй бөгөөд АХБ болон Засгийн газар түүний агуулгын төлөө хариуцлага хүлээхгүй.

@2024

Гарын авлагыг бичсэн:

“Хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг дэмжих”-“Тогтвортой Хөгжлийн Зорилгын үр нөлөөний хэмжилт, тайлагнал” техникийн туслалцааны төслийн зөвлөх баг:

Зөвлөх:

Г. Цэвээндорж
М. Тулга
Б. Ариунзаяа
С. Золжаргал

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр:

Хөтөлбөрийн шинжээч:

Т. Дэлгэрнаран

Тогтвортой санхүүжилт хариуцсан

мэргэжилтэн:

Д. Цолмон

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	5
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	5
НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ	6
ТАНИЛЦУУЛГА.....	7
1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	8
1.1 Баримталсан зарчим.....	8
1.2 Бондын татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжих зардал	9
1.3 Хамрах хүрээ	9
1.4 Татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, сонгох, үнэлэх, баталгаажуулах	10
2. ТХЗ-ТОЙ ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ ХОЛБОХ.....	11
3. ТХЗ-ТОЙ ХОЛБОГДСОН ЗАРЛАГЫГ БОНДЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЯЛДУУЛАХ	13
4. ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТТАЙ ТУЛГАХ.....	14
5. ЗАРДАЛ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ	17
5.1 Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл	18
5.2 ТХЗ-ЫН НӨЛӨӨЛӨЛ.....	19
5.3 Үр шим хүртэгч	21
5.4 ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТИЙН ТҮВШИН	22
5.5 Байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	23
6. ЗАРДАЛ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ҮНЭЛЭХ, СОНГОХ.....	24
6.1 Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл (нийт 28 хүртэл оноо)	24
6.2 ТХЗ-ЫН НӨЛӨӨЛӨЛ (нийт 40 хүртэл оноо)	25
6.3 ТХЗ-ийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийн түвшин (нийт 32 хүртэл оноо)	29
6.4 Байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл (нийт “-30” хүртэл оноо)	30
7. ЗАРДАЛ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛГААЖУУЛАХ.....	34
ДҮГНЭЛТ.....	34
ХАВСРАЛТ	37
АШИГЛАСАН НОМ ЗҮЙ	59

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. ТХЗНБ-ын баримт бичигт хамаарах салбар болон яамд	9
Хүснэгт 2. ТХЗ-ыг төсвийн зарлагатай холбосон жишээ (Эрчим хүч)	12
Хүснэгт 3. ТХЗНБ-ын баримт бичигт туссан “Сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний хэмнэлт” гэсэн салбарын ангиллын ТХЗНБ-ийн шалгуур үзүүлэлт, түүний кодчилол 13	
Хүснэгт 4. ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлттэй уялдсан зардал, төсөл, арга хэмжээний жагсаалт (Эрчим хүч)	14
Хүснэгт 5. Зардал, төсөл, арга хэмжээг хориглох үйл ажиллагааны жагсаалттай уялдуулах (Эрчим хүч)	15
Хүснэгт 6. Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл	18
Хүснэгт 7. ТХЗ-ын нөлөөлөл	20
Хүснэгт 8. Үр шим хүртэгч	22
Хүснэгт 9. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн түвшин	23
Хүснэгт 10. Байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл	23
Хүснэгт 11. Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээллийн үнэлгээ	25
Хүснэгт 12. ТХЗ-ын нөлөөллийг үнэлэх	26
Хүснэгт 13. 1 сая төгрөг тутамд ноогдох үр шим хүртэгчдийн тоон үзүүлэлтийг үнэлэх	28
Хүснэгт 14. Зардал, төсөл, арга хэмжээний үнэлэх сонгох онооны хүснэгт	32

Зургийн жагсаалт

Зураг 1. ТХЗНБ-ын баримт бичигт туссан зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, сонгох үе шат	10
Зураг 2. ТХЗНБ-ын баримт бичигт туссан зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, сонгох үе шат бүрд оролцох яам, төрийн байгууллагын ажил, үүргийн хуваарь	10
Зураг 3. Сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний хэмнэлт ангиллын жишээ	27
Зураг 4. Монгол Улсын 2023 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн хураангуй	29

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. ТХЗНБ-оор санхүүжих боломжтой зардал, төсөл, арга хэмжээний жагсаалт (Жишээ)	37
Хавсралт 2. ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлтийн дугаарлалт	46
Хавсралт 3. Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх сонгох үйл ажиллагааны үр дүн	50
Хавсралт 4. Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх онооны хүснэгт	56
Хавсралт 5. Саналын маягт	58

Нэр томъёоны товчлол

ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
НБЗ	Ногоон бондын зарчмууд
НИБЗ	Нийгмийн бондын зарчмууд
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУХЗЗХ	Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо
СЭХ	Сэргээгдэх эрчим хүч
ТӨУҮГ	Төрийн өмчит улсын үйлдвэрийн газар
ТХБУ	Тогтвортой хөгжлийн бондын удирдамж
ТХЗ	Тогтвортой Хөгжлийн Зорилгууд
ТХЗНБ	Тогтвортой Хөгжлийн Зорилгуудтай Нийцсэн Бонд
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ЭХХ	Эрчим хүчний хэмнэлт

Танилцуулга

Монгол Улсын Засгийн газар олон улсын бондын стандартуудыг хангасан “Тогтвортой Хөгжлийн Зорилгуудтай Нийцсэн Бонд (ТХЗНБ)”-ын Баримт Бичгийг 2023 онд гаргасан. Тус баримт бичгийн “Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт”, “Зардлыг үнэлэх, сонгох” гэсэн хэсгүүдийг хэрхэн хийж гүйцэтгэх дэлгэрэнгүй аргачлалыг боловсруулж энэ гарын авлагад оруулав.

ТХЗ-той уялдуулах зорилгоор 6 үе шат бүхий аргачлалын дагуу ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг бүрэн хангаж буй зардал, төсөл, арга хэмжээг хэрхэн үнэлж, сонгохыг тус гарын авлагад тусгав.

Зардал, төсөл, арга хэмжээний ТХЗ-той уялдсан байдал, ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлттэй нийцсэн байдал, ТХЗНБ-ын хориглох үйл ажиллагаатай уялдсан байдлыг салбарын яамд хэрхэн тодорхойлж зардал, төсөл, арга хэмжээний саналын жагсаалт, маягт бэлтгэх аргачлалыг тус гарын авлагад оруулсан. Саналын маягтаар ирүүлсэн зардал, төсөл, арга хэмжээг ТХЗНБ-ын баримт бичигт туссан онооны хүснэгтийн дагуу Сангийн яам хэрхэн үнэлж, шаардлага хангасан зардал, төсөл, арга хэмжээг сонгох аргачлалыг дэлгэрэнгүй тайлбарлав. Гарын авлагыг ашиглахад хялбар болгох зорилгоор Эрчим хүчний салбарын зарим зардал, төсөл, арга хэмжээг жишээ болгон авч үзсэн.

ТХЗНБ-ын баримт бичигт туссан 10 салбарт хамаарах 9 яамны 2023 оны улсын төсөвт батлагдсан зардал, төсөл, арга хэмжээг ТХЗ, ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлт, хориглох үйл ажиллагаатай уялдуулах, жагсаалт бэлтгэх, саналын маягт бэлтгэх, онооны хүснэгтийн дагуу үнэлгээ, сонголт хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус ажлыг гүйцэтгэсэнтэй холбоотой дэлгэрэнгүй хүснэгт, жагсаалт, баримт бичгүүдийг хавсралтад тусгав.

1. Ерөнхий зүйл

Сангийн яамнаас “Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудтай Нийцсэн Бондын Баримт Бичиг”-ийг (цаашид “ТХЗНБ-ын баримт бичиг” гэх) 2023 онд гаргасан. Энэхүү ТХЗНБ-ын баримт бичгийн зорилго нь Монгол Улс ТХЗ-той нийцсэн байгаль орчин, нийгмийн үр өгөөжийг бий болгох шаардлагыг хангасан зардал, төсөл, арга хэмжээ (зардлын зориулалт гэж ойлгоно)-г сонгож, тухайн бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр шинээр эсвэл дахин санхүүжүүлэх, бондын зарцуулалт болон байгаль орчин, нийгэмд үзүүлж буй нөлөөллийг тайлагнах зэрэг үйл ажиллагаатай холбоотой нөхцөл, үйл явцыг тодорхойлох юм (ТХЗНБ-ын баримт бичиг, 2023).

Уг бондын баримт бичгийг боловсруулахдаа Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (ОУХЗЗХ)-ноос нийтэлсэн Ногоон бондын зарчмууд (НБЗ), Нийгмийн бондын зарчмууд (НБЗ) болон Тогтвортой хөгжлийн бондын удирдамж (ТХБУ) зэрэг олон улсын бондын стандартуудтай нийцүүлсэн (ТХЗНБ-ын баримт бичиг, 2023).

ТХЗНБ-ын баримт бичиг нь ОУХЗЗХ-ны бондын зарчмуудын дагуу доорх дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг. Үүнд:

- I. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт
- II. Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох
- III. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага
- IV. Тайлагнал

Энэхүү гарын авлагад татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, сонгох үйл явцыг дэлгэрэнгүй байдлаар авч үзнэ. Өөрөөр хэлбэл, “1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт”, “2. Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох” -той холбоотой үйл ажиллагаа, арга хэмжээг тус гарын авлагад тайлбарлана.

1.1 Баримталсан зарчим

ТХЗНБ гаргах замаар Монгол Улс дараах зарчмын дагуу сонгогдсон Тогтвортой Хөгжлийн Зорилгууд буюу хэд хэдэн зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой төсвийн зардлыг санхүүжүүлнэ. Үүнд:

Зарчим 1. Үндэсний хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах

Зарчим 2. Хэрэгжилтийн хувьд хоцрогдолтой байгаа ТХЗ

Зарчим 3. Хамгийн их нэмэлт санхүүжилт шаардлагатай

Зарчим 4. Суурь асуудлыг шийдэх боломжтой болон бусад ТХЗ-д хувь нэмэр оруулах ач холбогдолтой

Зарчим 5. Монгол Улсын ногоон болон ТХЗ-ын санхүүжилтийн таксономитой уялдсан буюу нөлөөллийг нь хэмжих боломжтой ТХЗ

Санхүүжүүлэх боломжит зардал нь дараах шалгуурт нийцсэн байх ёстой. Үүнд:

- ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдсан салбарт хамаарах зардал байх
- Монгол Улсын Засгийн газрын төсвийн бодлогод нийцсэн байх
- Санал болгож буй ТХЗ-той нийцсэн бондын хугацаа, хөрөнгө оруулалтын төлөвлөсөн хугацаатай нийцэхүйц байх
- ТХЗНБ-ын баримт бичигт заасан тайлагналын шаардлагыг зохих түвшинд хангах

ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх зардал, төсөл, арга хэмжээг салбарын яамд сонгохдоо төсөв, санхүүгийн харилцааг зохицуулсан хууль, журмыг баримтлах бөгөөд хөрөнгө оруулалтын зардлыг үнэлэх, сонгохдоо Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д дурдсан шаардлагыг хангасан зардал, төсөл, арга хэмжээг сонгоно.

Хүлээн зөвшөөрөгдөх зардлуудад хөрөнгө оруулалтын зардал, төсвийн зардал (татвараас чөлөөлөгдсөн), татаас болон үйл ажиллагааны зардал, мөн ТХЗНБ гаргахаас 3-аас илүүгүй жилийн өмнө байгаль орчин, нийгмийн чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын шаардлага хангасан зардлыг хэрэгжүүлэхэд зориулж зарцуулсан бусад зардал багтаж болно. *Тусгай зориулалттай эх үүсвэрээр өмнө нь санхүүжүүлсэн зардлыг давхардуулан санхүүжүүлэхээс зайлсхийхийн тулд тухайн зардлыг зөвшөөрөгдөх зардалд тооцохгүй.*

1.2 Бондын татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжих зардал

ТХЗНБ-ын баримт бичгийн хүрээнд Монгол Улс ТХЗ-той нийцсэн бонд гаргаж, татан төвлөрүүлсэн хөрөнгийг Монгол Улсын ТХЗ, Үндэсний Тодорхойлсон Хувь Нэмэр зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн зардлуудад зарцуулна.

Бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр дараах зардлуудыг санхүүжүүлэхээр ТХЗНБ-ын баримт бичигт тусгасан байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын зардал;
- Татаас, зээл, тусламж;
- Татварын зардал (татварын хөнгөлөлт, чөлөөлөлт);
- Үйл ажиллагааны зардлууд;
- Интервенцийн зардлууд (ТӨУҮГ олгох шилжүүлэг, татаас).

1.3 Хамрах хүрээ

ТХЗ-той нийцсэн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг бий болгох шаардлагыг хангасан 10 салбар, уг салбаруудын бодлого, үйл ажиллагааг шууд хариуцах 9 яаманд хэрэгжих зардал, төсөл, арга хэмжээ нь уг ТХЗНБ-ын баримт бичгийн хамрах хүрээнд багтаж байна.

Хүснэгт 1. ТХЗНБ-ын баримт бичигт хамаарах салбар болон яамд

	ТХЗНБ-ын баримт бичигт хамаарах салбар	Салбарын яам
1	Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж	Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын сан
2	Боловсролын хүртээмж	Боловсрол, шинжлэх ухааны яам Соёлын яам
3	Сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний хэмнэлт	Эрчим хүчний яам
4	Тогтвортой хот, дэд бүтэц ба орон сууц	Барилга, хот байгуулалтын яам
5	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүд, залуучуудыг дэмжих	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Боловсрол, шинжлэх ухааны яам
6	Бохирдлоос сэргийлэх, бууруулах	Байгаль орчин, аялал жуулчлалын яам Эрчим хүчний яам Барилга, хот байгуулалтын яам
7	Ус, хог хаягдлын зохистой хэрэглээ, менежмент	Байгаль орчин, аялал жуулчлалын яам Барилга, хот байгуулалтын яам

8	Тогтвортой хөдөө аж ахуй ба хүнсний аюулгүй байдал	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
9	Тогтвортой газар ашиглалт, ойн аж ахуй, биологийн олон янз байдлыг хамгаалах, эко аялал жуулчлал	Байгаль орчин, аялал жуулчлалын яам Барилга, хот байгуулалтын яам
10	Цэвэр, тогтвортой тээвэр	Зам, тээврийн хөгжлийн яам Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд


ТХЗ-ыг төсвийн зарлагатай холбох (SDG Budget Tagging) ажил, ТХЗ-той холбогдсон зарлагыг Бондын шалгуур үзүүлэлттэй нийцүүлэх ажлыг салбарын яамнууд хийж гүйцэтгэн Сангийн яам баталгаажуулна.

1.4 Татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, сонгох, үнэлэх, баталгаажуулах

ТХЗ-той нийцсэн байгаль орчин, нийгмийн үр өгөөжийг бий болгох зардал, төсөл, арга хэмжээг сонгох нь ТХЗНБ-ын үндсэн зорилгуудын нэг билээ. ТХЗНБ-ын баримт бичигт туссан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан зардал, төсөл, арга хэмжээг дараах 6 үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.

1. ТХЗ-той төсвийн зарлагыг холбох
2. ТХЗ-той холбогдсон зарлагыг Бондын шалгуур үзүүлэлттэй уялдуулах
3. Хориглох үйл ажиллагааны жагсаалттай тулгах
4. Зардал, төсөл, арга хэмжээний санал хүргүүлэх (дэлгэрэнгүй жагсаалт)
5. Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох (хураангуй жагсаалт)
6. Зардал, төсөл, арга хэмжээг баталгаажуулах


Зураг 1. ТХЗНБ-ын баримт бичигт туссан зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, сонгох үе шат



Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

ТХЗНБ-ын баримт бичигт туссан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, сонгох 6 үе шат тус бүрд салбарын яам, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам хэрхэн оролцох ажил, үүргийн хуваарийг дараах зурагт үзүүлээ. Зардал, төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн бодлоготой уялдаж байгаа эсэхэд Эдийн засаг, хөгжлийн яам тусгайлан дүгнэлт санал өгч болно.

Зураг 2. ТХЗНБ-ын баримт бичигт туссан зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, сонгох үе шат бүрд оролцох яам, төрийн байгууллагын ажил, үүргийн хуваарь



Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

2. TX3-той төсвийн зарлагыг холбох

TX3-ыг төсвийн зарлагатай холбох¹ нь бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл арга хэмжээг тодорхойлох үнэлэх, сонгох ажлын хамгийн анхан шатны үе шат юм. TX3-той төсвийн зарлагыг холбох аргачлалыг тусгайлан боловсруулж, улмаар холбох ажлыг TX3НБ-ын баримт бичигт туссан салбар, яамдын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Тухайлбал, Монгол Улсын хувьд анх удаагаа 2023 онд TX3НБ-ын баримт бичигт туссан 10 салбар, 9 яамны хүрээнд TX3-ыг 2023 оны улсын төсвийн зарлагатай холбосон. Харин Улсын төсөвт туссан зардал, төсөл, арга хэмжээнээс гадна орон нутгийн төсөв, Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж байгаа зардал, төсөл, арга хэмжээг харгалзан үзсэн бол илүү олон байгаль орчин, нийгэм, эдийн засагт эерэг нөлөөтэй зардал, төсөл, арга хэмжээг сонгох боломжтой юм. Мөн боломжит зардал, төсөл, арга хэмжээний нэмэлт жагсаалтыг Хавсралт 1-д тусгасан.

TX3-той төсвийн зарлагыг холбох ажлын үр дүн, аргачлалыг тус гарын авлагад давхардуулан нарийвчлан тусгаагүй болно.

¹ TX3-той төсвийн зарлагыг холбох гарын авлага

ТХЗ-той төсвийн зарлагын холбох ажлыг хийж гүйцэтгэсэн мэдээлэл, жагсаалтад үндэслэн ТХЗНБ-ын баримт бичигт туссан ТХЗ-той нийцсэн зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, сонгох, үнэлэх, баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

ТХЗ-той нийцсэн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг бий болгох шаардлагыг хангасан зардал, төсөл, арга хэмжээг сонгох үйл ажиллагааг ойлгомжтой тайлбарлах зорилгоор Эрчим хүчний яамны зарим зардал, төсөл, арга хэмжээг жишээ болгон авсан.

Салбарын яамдын хувьд Бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр зарим зардал, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх хүсэлтэй байгаа бол тухайн зардлыг ТХЗ-той эхний шатанд уялдуулж, холбосон байх шаардлагатай. Эрчим хүчний салбарын хэмжээнд хийж гүйцэтгэсэн ТХЗ-той төсвийн зарлагыг холбох ажлын үр дүн болох зарим зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтыг жишээ болгон Хүснэгт 2-т үзүүлэв.

Хэрэв төсвийн зарлагыг ТХЗ-той холбоогүй бол тухайн салбарын яам өөрийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан, ТХЗ-той нийцсэн зардлыг тодорхой шалгуурын дагуу эрэмбэлж, сонгон авч болно. Ингэхдээ тус гарын авлагад туссан “Баримталсан зарчим” хэсэгт дурдсан зарчим, бодлоготой нягт уялдсан зардал, төсөл, арга хэмжээг сонгоно.

Эрчим хүчний салбарын хувьд ТХЗ-ын 7, 11 гэсэн зорилгуудтай уялдаж байгааг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 2. ТХЗ-ыг төсвийн зарлагатай холбосон жишээ (Эрчим хүч)

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	Дүн (сая.төг)	ТХЗ- ын дугаар	ТХЗ-ын зорилтын дугаар	ТХЗ-ын зорилтын дэлгэрэнгүй
Эрчим хүчний алдагдлын татаас	71,874.4	7	7.1	Зорилт 7.1 2030 он гэхэд боломжийн, найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээгээр хүн бүрийг хангах
Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/	11,294.7	7	7.1	Зорилт 7.1 2030 он гэхэд боломжийн, найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээгээр хүн бүрийг хангах
Аймгийн төвийн 220/110/35 кВ Мандал дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/	478.4	7	7.1	Зорилт 7.1 2030 он гэхэд боломжийн, найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээгээр хүн бүрийг хангах
Дулааны цахилгаан станцын өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум/	58,375.8	11	11.1	Зорилт 11.1 2030 он гэхэд хүрэлцэхүйц, аюулгүй, хямд үнэтэй орон сууц, суурь үйлчилгээгээр хүн бүрийг хангаж, ядуусын хорооллыг сайжруулах

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

ТХЗ-той зардал, төсөл, арга хэмжээг холбохдоо ТХЗ-ын дугаар, ТХЗ-ын зорилтын дугаар, ТХЗ-ын зорилтын дэлгэрэнгүй тайлбарыг харгалзах багана тус бүрд бичнэ. Тухайлбал, “Эрчим хүчний алдагдлын татаас” гэсэн зардлын зориулалтыг ТХЗ-той холбохдоо “ТХЗ-ын дугаар” гэсэн баганатай харгалзах мөрөнд “7”, “ТХЗ-ын зорилтын дугаар” гэсэн баганатай харгалзах мөрөнд “7.1” гэж тус тус бичнэ. ТХЗ-ын зорилтын дэлгэрэнгүй тайлбарыг “ТХЗ-ын зорилт” гэсэн баганад “Зорилт 7.1 2030 он гэхэд боломжийн, найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээгээр хүн бүрийг хангах” гэж бичнэ.

Мөн бусад зардал, төсөл, арга хэмжээ нь ТХЗ-той хэрхэн уялдаж байгааг дээрх хүснэгтээс харах боломжтой.

Энэ жишээг дараагийн үе шат болох “зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, сонгох” үеүдэд дэлгэрүүлэн цааш тайлбарлана.

ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, сонгох, үнэлэх, баталгаажуулахаас өмнө салбарын яамд ТХЗ-той төсвийн зарлагыг холбох ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Уг ажлыг Сангийн яам баталгаажуулах бөгөөд баталгаажуулалт хийгдсэний дараа ТХЗ-той холбогдсон зарлагыг Бондын шалгуур үзүүлэлттэй уялдуулах ажил хийгдэнэ.

3. ТХЗ-той холбогдсон зарлагыг Бондын шалгуур үзүүлэлттэй уялдуулах

Энэ үе шатанд ТХЗ-той төсвийн зарлагыг холбосны дараа бэлэн болсон зардлын жагсаалтыг ТХЗНБ-ын баримт бичигт туссан бондын шалгуур үзүүлэлттэй уялдуулах ажлыг гүйцэтгэнэ. Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахгүй байгаа зардал, төсөл, арга хэмжээг жагсаалтаас хасна. Харин ТХЗНБ-ын баримт бичигт туссан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж байгаа зардал, төсөл, арга хэмжээг сонгож, дараагийн шатанд үлдэнэ. Өөрөөр хэлбэл, дараагийн шатанд үлдсэн зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтыг Хориглох үйл ажиллагааны жагсаалттай тулгана.

Уг шалгуур үзүүлэлттэй уялдуулах ажлыг салбарын яамнууд хийж гүйцэтгэх шаардлагатай.

Уялдуулах ажлыг хийж гүйцэтгэхдээ ТХЗ-той уялдсан ТХЗНБ-ын баримт бичигт туссан 10 салбарын шалгуур үзүүлэлт тус бүрд тусгай код өгч уг кодоор нь холбогдох зардал, төсөл, арга хэмжээг ангилах, сонгох нь илүү хялбар юм. Салбар бүрээр тодорхойлсон ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлт тус бүрийг кодчилсон ангиллыг Хавсралт 2-т оруулав.

Хавсралт 2-т дурдсан “Сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний хэмнэлт” гэсэн эрчим хүчний салбарын ангилалд хамаарах ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлтийн кодчиллын зарим хэсгийг жишээ болгон доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 3. ТХЗНБ-ын баримт бичигт туссан “Сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний хэмнэлт” гэсэн салбарын ангиллын ТХЗНБ-ийн шалгуур үзүүлэлт, түүний кодчилол

Салбарын ангилал	ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлт	Кодчилол
3. Сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний хэмнэлт	СЭХ-ний эх үүсвэр болох нар, салхи, усны эрчим, газрын гүний дулаан, ногоон устөрөгч, биомасс зэрэг байгалийн байнга нөхөн сэргэх нөөцийн үүсгүүр байгууламжийг барих, сэргээн засварлах, засвар үйлчилгээ хийх болон үйл ажиллагаатай холбоотой.	ЕС.3.1
	Сэргээгдэх эрчим хүчийг нөөцлөх, дамжуулах сүлжээгээр дамжуулах	ЕС.3.2
	Эрчим хүч, аж үйлдвэр, барилгын салбарт эрчим хүчний хэмнэлтийг дээшлүүлэх	ЕС.3.3
	Цахилгаан хангамжийн бүтцийн өөрчлөлт хийх, түвшнийг дээшлүүлэх, одоо байгаа шугам сүлжээнээс алслагдсан хот, тосгон, сум, суурин газруудыг шугам сүлжээнд холбож, цахилгаанжуулах төсөл хөтөлбөрүүд	ЕС.3.4

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

ТХЗ-ыг төсвийн зарлагатай холбосон зардал, төсөл, арга хэмжээний жагсаалт дээр үргэлжлүүлэн хүснэгт 4-т үзүүлсэнчлэн ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлтийн кодыг ашиглан уялдуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Тухайлбал, “ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлт” баганад “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/” гэсэн зардал ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлттэй хэрхэн уялдаж байгааг дээр дурдсан кодыг ашиглан тодорхойлно. Доорх хүснэгтээс харахад “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/” гэсэн зардал нь “ЕС.3.2. Сэргээгдэх эрчим хүчийг нөөцлөх, дамжуулах сүлжээгээр дамжуулах” гэсэн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа тул “ЕС.3.2” гэсэн кодыг харгалзах мөрөнд бичиж холболтыг хийнэ. Мөн ТХЗНБ-ын баримт бичигт туссаны дагуу уг зардал нь ямар зардлын ангилалд хамаарч байгааг ялгаж өгнө. “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/” гэсэн зардал нь хөрөнгө оруулалтын зардалд хамаардаг тул “Хөрөнгө оруулалтын зардал” гэсэн зардлын ангиллыг сонгоно.

Хүснэгт 4. ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлттэй уялдсан зардал, төсөл, арга хэмжээний жагсаалт (Эрчим хүч)

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	Дүн (сая.төг)	ТХЗ-ын зорилтын дугаар	ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлт	Зардлын ангилал
Эрчим хүчний алдагдлын татаас	71,874.4	7.1	ЕС.3.4	Урсгал зардал
Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/	11,294.7	7.1	ЕС.3.2	Хөрөнгө оруулалтын зардал
Аймгийн төвийн 220/110/35 кВ Мандал дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/	478.4	7.1	ЕС.3.4	Хөрөнгө оруулалтын зардал
Дулааны цахилгаан станцын өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум/	58,375.8	11.1		Хөрөнгө оруулалтын зардал

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

Хүснэгт 4 -өөс харахад жишээ болгон авсан зардал, төсөл, арга хэмжээнүүдийн 3 нь ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлтийг хангаж, 1 нь хангахгүй байна. “Дулааны цахилгаан станцын өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум/” гэсэн зардал нь ТХЗНБ-д хамаарахгүй байна. Учир нь дулаан үйлдвэрлэлтэй холбоотой аливаа зардал, төсөл, арга хэмжээ нь ТХЗНБ-д тусаагүй юм. Иймд тус зардалтай харгалзах баганад кодыг бичихгүй бөгөөд уг жагсаалтаас хасна.

“Эрчим хүчний алдагдлын татаас”, “Аймгийн төвийн 220/110/35 кВ Мандал дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/” гэсэн зардлууд нь ТХЗНБ-ын баримт бичигт туссан Бондын шалгуур үзүүлэлттэй бүрэн уялдаж байгаа тул хамаарах код “ЕС.3.4”-ыг харгалзах мөрөнд тус тус бичнэ. Зардлын ангиллын хувьд “Эрчим хүчний алдагдлын татаас” нь урсгал зардалд хамаардаг тул “Урсгал зардал” гэсэн зардлын ангилал юм. Харин “Аймгийн төвийн 220/110/35 кВ Мандал дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/” зардал нь “Хөрөнгө оруулалтын зардал”-д хамаарна.

ТХЗНБ-ын баримт бичигт туссан 9 яамны хэмжээнд, 10 салбарын ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлт бүрээр уялдуулах ажлыг хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг Хавсралт 3-аас үзнэ үү.

4. Хориглох үйл ажиллагааны жагсаалттай тулгах

Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн хориглосон үйл ажиллагааны жагсаалтад орсон үйл ажиллагааг Монгол Улсын ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй. Хориглох үйл ажиллагааны

жагсаалт нь байгаль орчинд ээлгүй зардал, үйл ажиллагаа болон олон улсын гэрээ конвенц, Монгол Улсын хуулиар хориглосон зардал, үйл ажиллагааг тодорхой зааж өгсөн байдаг.

ТХЗНБ-ын баримт бичигт туссан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтыг Хориглох үйл ажиллагааны жагсаалттай нэг бүрчлэн тулгалт хийж уг хориглох үйл ажиллагааны жагсаалтад багтаж байвал ТХЗНБ-оор санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтаас хасна. Хориглох үйл ажиллагааны жагсаалтад хамаарах зардлыг хассаны дараа үлдэх зардал, төсөл, арга хэмжээний жагсаалт нь ТХЗ болон ТХЗНБ-ын баримт бичигт туссан шалгуур үзүүлэлттэй уялдсан, шаардлага хангаж буй зардлын жагсаалт юм. Уг тулгах ажлыг салбарын яамнууд хийж гүйцэтгэнэ.

Зардал, төсөл, арга хэмжээг хэрхэн уялдуулж байгааг Хүснэгт 5-аас харж болно. Тухайлбал, Эрчим хүчний салбарын Бондын шалгуур үзүүлэлттэй уялдсан 2 зардал нь “Үгүй”, 1 зардал нь “Тийм” гэж ангилагдаж байна.

ТХЗНБ-ын баримт бичигт туссанаар Эрчим хүчний салбарын хэмжээнд чулуужсан түлш (fossil fuel) буюу газрын тос, нүүрс, байгалийн хий зэрэг сэргээгдэх боломжгүй байгалийн нөөцийн хайгуул, олборлолт, үйлдвэрлэл, тээвэрлэлт зэрэгтэй холбоотой аливаа үйл ажиллагааг бүрэн хориглодог. Иймд аливаа нүүрс хэрэглэж дулаан үйлдвэрлэдэг станц, түүний өргөтгөл, холбогдох тоног төхөөрөмж зэрэг зардлууд нь хориглох үйл ажиллагааны жагсаалтад багтаж байгаа тул татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжгүй юм.

Хэрэв Хориглох үйл ажиллагааны жагсаалтад хамаарч, “Тийм” гэж ангилагдсан бол уг зардлыг шаардлага хангахгүй зардал гэж жагсаалтаас хасна. Тухайлбал, “Эрчим хүчний алдагдлын татаас” нь нүүрс ашигладаг дулааны станцуудад олгогддог бол ТХЗНБ-ын баримт бичигт туссан Хориглох үйл ажиллагаанд хамаарч байгаа юм. Иймд “Хориглох үйл ажиллагааны жагсаалтад хамаарч буй эсэх” гэсэн баганад “Эрчим хүчний алдагдлын татаас”-ыг “Тийм” гэж тэмдэглэнэ. Дараагийн шатанд уг зардал нь жагсаалтаас хасагдана.

Хүснэгт 5. Зардал, төсөл, арга хэмжээг хориглох үйл ажиллагааны жагсаалттай уялдуулах (Эрчим хүч)

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	Дүн (сая.төг)	ТХЗ-ын зорилтын дугаар	ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлт	Зардлын ангилал	Хориглох үйл ажиллагааны жагсаалтад хамаарч буй эсэх
Эрчим хүчний алдагдлын татаас	71,874.4	7.1	ЕС.3.4	Урсгал зардал	Тийм
Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/	11,294.7	7.1	ЕС.3.2	Хөрөнгө оруулалтын зардал	Үгүй
Аймгийн төвийн 220/110/35 кВ Мандал дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/	478.4	7.1	ЕС.3.4	Хөрөнгө оруулалтын зардал	Үгүй

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

Монгол улсын 2023 оны төсөвт туссан, хориглох үйл ажиллагаанд хамаарах зардал, төсөл, арга хэмжээ (эрчим хүчний салбарын нүүрс ашиглан дулаан үйлдвэрлэдэг станц болон холбогдох зардал, төсөл, арга хэмжээ)-үүд нь ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлттэй уялдуулах шатанд хасагдсан. Өөрөөр хэлбэл, зарим хориглох үйл ажиллагаанд хамаарах зардлууд нь хориглох үйл ажиллагааны жагсаалттай тулгах үе шатанд хүрэхээс өмнө хасагдсан байна.

“Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/”,
“Аймгийн төвийн 220/110/35 кВ Мандал дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/” гэсэн
2 зардал нь Хориглох үйл ажиллагаанд хамаарахгүй тул салбарын яам нь тус 2 зардлыг дараагийн шатанд
шилжүүлнэ.

Дараагийн шатанд салбарын яам нь зардал, төсөл, арга хэмжээний саналын жагсаалтыг холбогдох маягтын
дагуу бэлтгэж Сангийн яам руу илгээнэ.

5. Зардал, төсөл, арга хэмжээний санал

Зардал, төсөл, арга хэмжээний санал бэлтгэх үндсэн зорилго нь ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох, харьцуулж оноо өгөх буюу хураангуй жагсаалт (shortlists) гаргахад Сангийн яамыг шаардлагатай мэдээллээр хангах юм.

Салбарын яам тус бүр ТХЗНБ-ын баримт бичгийн “Хориглох үйл ажиллагаа” шатыг давсан буюу ТХЗНБ-ын баримт бичигт туссан шаардлагуудыг бүрэн хангасан зардал, төсөл, арга хэмжээнүүдийн жагсаалтыг үндэслэн санхүүжилт хүсэж буй зардлаа эрэмбэлэн, саналаа бэлтгэн Сангийн яаманд хүргүүлнэ. Санал бэлтгэхэд тус баримт бичгийн саналын маягтыг доор дурдсан зааврын дагуу бөглөн, нэмэлт дэлгэрэнгүй мэдээллийн хамт хүргүүлэх шаардлагатай.

Дэлгэрэнгүй мэдээлэл

Дэлгэрэнгүй мэдээлэл гэж доор дурдсанаас гадна зарим тохиолдолд тухайн зардал, төсөл, арга хэмжээг үнэн зөв үнэлэхэд Сангийн яамнаас шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичгүүд байна.

- Хөрөнгө оруулалтын зардлыг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-тай нийцүүлсэн байх.
- Урсгал зардлыг Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой хууль, журамтай бүрэн нийцүүлсэн байх
- Хэрэгжүүлэх болон хэрэгжиж буй зардал, төсөл, арга хэмжээний цаашдын төлөвлөгөө
- Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ

Саналын маягт

Салбар яамд доорх маягтыг бөглөнө. Маягт нь дараах 5 бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

1. Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл
2. ТХЗ-ын нөлөөлөл (SDG impact)
3. Үр шим хүртэгч (Beneficiary)
3. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн түвшин (SDG indicator rank)
4. Байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл (negative SDG impact)

Маягтыг бөглөх жишээ болгон энэхүү баримт бичгийн өмнөх бүлэгт авсан жишээнүүдийг үргэлжлүүлэн үзүүлэв.

5.1 Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл

Саналын маягтын ерөнхий мэдээлэл нь зардал, төсөл, арга хэмжээний нэр, дэд төсөл, хугацаа, шаардлагатай хөрөнгө оруулалт, эцсийн үр дүн зэрэг мэдээллийг агуулна.

Доорх жишээнд Эрчим хүчний салбарын төсвийн хөрөнгө оруулалтын зардлууд сонгогдсон байгаа тул цаашид “төсөл” гэж бичив (Мэдээллийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан энэхүү жишээнүүдэд зарим мэдээллийг бүрэн бус илэрхийлсэн байж болзошгүй).

“Төслийн нэр” нь тухайн хөрөнгө оруулалтын зардлыг Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд тусгасан нэр буюу төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад орсон нэр байна. Тухайлбал, “Аймгийн төвийн 220/110/35 кВ “Мандал” дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/” болон “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/” төслүүд төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад орсон нэрээр шууд бичигдсэн байна. Харин шинэ төсөл хэрэгжүүлэхээр бол салбарын санал болгож буй төслийн нэрийг тодорхойлж бичнэ.

“Дэд төсөл” хэсэгт тухайн төсөл нь 2 буюу түүнээс дээш тооны дэд төслүүдээс бүрдсэн бол тухайн харгалзах төслийн тоог бичнэ. Доорх жишээнүүд дэд төсөлгүй тул “0” гэж бичив.

“Төслийн хэрэгжих хугацаа” буюу эхлэх болон дуусах огноог бичнэ. Тухайлбал, “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/” төсөл нь Монгол Улсын 2023 оны төсөвт туссан бөгөөд уг төслийн хэрэгжих хугацаа нь 2019-2024 он байна. “Аймгийн төвийн 220/110/35 кВ “Мандал” дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/” төслийн хэрэгжих хугацаа нь 2021-2023 он байна.

“Төсөл хэрэгжихэд шаардлагатай хөрөнгө оруулалт” буюу санхүүжилтийг сая төгрөгөөр илэрхийлж бичнэ. Тухайлбал, “Аймгийн төвийн 220/110/35 кВ “Мандал” дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/” төсөл бүрэн хэрэгжихэд 478.4 сая төгрөг, “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/” төсөл бүрэн хэрэгжихэд 11,294.7 сая төгрөг шаардлагатай байна.

“Тайлбар” хэсэгт өмнө эхэлсэн байсан төслийн хувьд төслийн хугацаа болон шаардлагатай хөрөнгө оруулалтын уялдааг тайлбарлах шаардлагатай. Өмнө нь эхэлсэн байсан төслийн авсан санхүүжилтийн дүн болон эх үүсвэр, мөн яагаад ТХЗНБ-оор санхүүжих шаардлагатай болсон талаар товч тайлбарлах юм. Хэрэв төсөл ирээдүйд хэрэгжих төсөл бол ТХЗНБ-оор санхүүжих шаардлагатай төсөл гэж шууд ойлгогдоно, тиймээс тайлбар бичих шаардлагагүй. Доорх жишээнүүд Улсын төсөвт тусгагдсан төслүүд байгаа тул “тайлбар” хэсэгт “-” утга тавьсан байна.

Төсөл хэрэгжсэнээр гарах үр дүнг ТХЗ-той уялдсан байдлаар бичих бөгөөд 500 үгээс хэтрүүлэхгүй.

Салбарын яам нь төсөл хариуцах төсвийн ерөнхийлөн захирагч, төслийн нэгж, төслийн зохицуулагчийг тодорхойлсон байна.

Хүснэгт 6. Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл

Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл						
#	Нэр	Дэд төсөл	Хугацаа	Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ (сая төгрөгөөр)	Тайлбар	Хүрэх үр дүн (500 үгээс хэтрэхгүй)

1	Аймгийн төвийн 220/110/35 кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/	0	2021 оны 1 дугаар сарын 1-ээс 2023 оны 12 сарын 31 хооронд	478.4	-	Дундговь аймгийн Сайнцагаан сумын иргэдийн цахилгааны хүртээмжийг нэмэгдүүлэх. Эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байснаар аймгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хүүхдүүдийн боловсрол эзэмших боломж нэмэгдэх, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бий болгоход чухал үр нөлөөтэй юм.
2	Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/	0	2019 оны 1 дүгээр сарын 1-ээс 2024 оны 12 сарын 31 хооронд	11,294.7	-	Говь-Алтай аймгийн Алтай хотын иргэдийг найдвартай, тогтмол сэргээгдэх эрчим хүчээр хангах. Нүүрсээр үүсгэгдсэн эрчим хүчийг хэрэглэнээс хассанаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах байгаль орчны эерэг үр нөлөөтэй төсөл юм.

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

5.2 ТХЗ-ын нөлөөлөл

ТХЗНБ-оор санхүүжих төсөл нь ТХЗ-д эерэг хувь нэмэр оруулж байх шаардлагатай. Саналын маягтын тус хэсэгт тухайн зардал, төсөл, арга хэмжээ нь хэрхэн ТХЗ-той нийцэж байгааг тайлбарлана. Тухайн зардал, төсөл, арга хэмжээ нь байгаль орчин, нийгэм, эдийн засагт ямар нөлөөлөл үзүүлж байгаа талаар, үр нөлөөг ямар шалгуур үзүүлэлтээр хэмжих мөн тухайн төслийг хэрэгжүүлснээр үр шим хүртэгч нь хэн байх талаар тодорхойлно.

“ТХЗНБ-ын зөвшөөрөгдөх салбар” - ТХЗНБ-ын баримт бичиг нь 10 салбарыг хамарч байгаа бөгөөд тухайн санал болгож буй зардал, төсөл, арга хэмжээ нь уг 10 салбарын аль нэгд хамаарсан байх шаардлагатай. Доорх жишээнүүд ТХЗНБ-ын “Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг буюу хэмнэлт” гэсэн салбарт хамаарч байгаа тул харгалзах баганад бичигдсэн байна.

“Үндсэн ТХЗ”, “Шууд бусаар нөлөөлж буй ТХЗ” - ТХЗНБ-оор санхүүжих зардал, төсөл, арга хэмжээ нь нэг буюу түүнээс дээш ТХЗ-той хамааралтай байх шаардлагатай бөгөөд харгалзах ТХЗ-ыг энэхүү саналын маягтад тодорхойлно. Хэрэв тухайн зардал, төсөл, арга хэмжээ нь ТХЗ-той холбогдсон (SDG budget tagging) бол тухайн ТХЗ-ын дугаарыг “Үндсэн ТХЗ” баганын харгалзах мөрөнд бичнэ. Хэрэв холбогдоогүй бол хамгийн их хамааралтай ТХЗ-ыг “Үндсэн ТХЗ” баганад бичнэ. Хоёр буюу түүнээс олон ТХЗ-той холбогдсон зардал, төсөл, арга хэмжээний хувьд тэдгээр нэмэлт ТХЗ-ын дугааруудыг “Шууд бусаар нөлөөж буй ТХЗ” баганын харгалзах мөрөнд тавина. Жишээ болгон авсан 2 санал нь хоёул “Үндсэн ТХЗ” баганад “7”, “Шууд бусаар нөлөөлж буй ТХЗ” баганад “11, 9, 8” ТХЗ-той уялдсан байна.

“ТХЗ-той хэрхэн уялдаж буй тайлбар” - ТХЗ-ын дугаарыг хүснэгтийн харгалзах хэсэгт бөглөсний дараа тухайн төсөл нь хэрхэн ТХЗ-той холбогдож буй талаар тайлбарыг 500 үгээс хэтрүүлэхгүй бичнэ. Тухайлбал, сонгон авсан жишээнүүд нь ТХЗ-ын зорилтын түвшинд “ТХЗ 7.1”-ыг шууд хангаж байгааг тайлбарлав.

“Байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө” - Хэрэгжүүлэх зардал, төсөл, арга хэмжээ нь байгаль орчин, нийгэм, эдийн засагт эерэг нөлөөтэй байх хэрэгтэй. Тухайлбал, доорх жишээнд үзүүлсэн эрчим хүчний станцын өргөтгөл болон эрчим хүчний шугам татах ажил хийгдсэнээр иргэдийн найдвартай эрчим хүчээр хангагдах боломж нэмэгдэж, улмаар эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах, сурч боловсрох орчин

сайжрах боломжтой юм. Эрчим хүчний станцын өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэх явцад ажлын байр бий болох бөгөөд өргөтгөл ашиглалтад орсны дараа үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэж ажлын байр шинээр бий болох боломжтой. “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/” төсөл хэрэгжих нь сэргээгдэх эрчим хүчний түгээлтийг нэмэгдүүлнэ. Мөн байгаль орчинд сөрөг нөлөөгүй, сэргээгдэх эрчим хүчний ашиглалт нэмэгдэж буй талаар тайлбарласан байгааг доорх жишээнээс харж болно.

“Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт” - Зардал, төсөл, арга хэмжээ нь ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжсэн тохиолдолд уг төслийг хэрэгжүүлснээр бий болох нөлөөллийг цаашид жилд нэгээс доошгүй удаа тайлагнах үүргийг МУ-ын Засгийн газар бондын хөрөнгө оруулагчийн өмнө хүлээнэ. ТХЗНБ-ын баримт бичигт зөвшөөрөгдсөн зардлын шинж чанар, тоон мэдээллийн хүртээмжтэй байдлыг харгалзан нөлөөллийг хэмжих боломжит шалгуур үзүүлэлтүүдийг тусгаж өгсөн.

Зардал, төсөл, арга хэмжээний нөлөөллийг хэмжих гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг саналын маягтын харгалзах хэсэгт бичнэ. Хэрэв санал бэлтгэхээр төлөвлөж буй зардал, төсөл, арга хэмжээний нөлөөллийг хэмжих боломжит шалгуур үзүүлэлт ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдаагүй бол тухайн төслийн нөлөөллийг үнэлэх оновчтой шалгуур үзүүлэлтийг тодорхойлж маягтын харгалзах хэсэгт бичнэ.

Хүснэгт 7. ТХЗ-ын нөлөөлөл

ТХЗ-ын нөлөөлөл						
#	ТХЗНБ-ын зөвшөөрөгдөх салбар	Үндсэн ТХЗ	Шууд бусаар нөлөөлж буй ТХЗ	ТХЗ-той хэрхэн уялдаж буй тайлбар (500 үгээс хэтрэхгүй)	Зардал, төсөл, арга хэмжээ хэрэгжсэнээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлөх вэ? Үр нөлөө гарах хугацаа	Зардал, төсөл, арга хэмжээний нөлөөг хэмжихийн тулд ашиглах гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
1	Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг буюу хэмнэлт	7	11, 9 болон 8	1. ТХЗ 7: Эрчим хүчний станцын өргөтгөлийн ажил нь ТХЗ-ын зорилт 7.1 буюу "2030 он гэхэд боломжийн, найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээгээр хүн бүрийг хангах" зорилтыг шууд хангаж байна. 2. ТХЗ 11: Станцын өргөтгөлийн ажил хийгдсэнээр тухайн орон нутагдах айл өрх, албан байгууллагууд найдвартай, нэгдсэн цахилгаан эрчим хүчээр хангагдах бөгөөд үүний үр дүнд суурь үйлчилгээ, орон сууцны хангамж хүрэлцэхүйц болж аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр хангагдана. 3. ТХЗ 9: Хүн бүрд тэгш, хүртээмжтэй, эдийн засгийн хөгжил, хүний сайн сайхан аж байдлыг дэмжих, чанартай, найдвартай, тогтвортой, уян хатан дэд бүтэц бий болж буй хэлбэр тул ТХЗ 9-ийг хангаж байна. 4: ТХЗ 8: Эрчим хүчний станцын өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэх явцад ажлын байр бий болох бөгөөд өргөтгөл ашиглалтад орсны дараа ажлын байр нэмэгдэх боломжтой.	1. Станцын үйл ажиллагааг хэрэгжүүлэх иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж улмаар нийгэм, эдийн засгийн эерэг нөлөө төсөл хэрэгжиж дуусмагц гарна. 2. Дэд бүтэц сайжирснаар иргэдийн амьдрах, ажиллах, суралцах орчин нөхцөл сайжирч, нийгмийн эерэг үр нөлөө дунд болон урт хугацаандаа гарах боломжтой.	1. Шинээр эрчим хүчинд холбогдсон өрхийн тоо 2. Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын нийт хүн амд эзлэх хувь

2	Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг буюу хэмнэлт	7	11, 9 болон 8	1. ТХЗ 7: Эрчим хүчний станцын өргөтгөлийн ажил нь ТХЗ-ын зорилт 7.1 буюу "2030 он гэхэд боломжийн, найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээгээр хүн бүрийг хангах" зорилтыг шууд хангаж байна. 2. ТХЗ 11: Станцын өргөтгөлийн ажил хийгдсэнээр тухайн орон нутагдах айл өрх, албан байгууллагууд найдвартай, нэгдсэн цахилгаан эрчим хүчээр хангагдах бөгөөд үүний үр дүнд суурь үйлчилгээ, орон сууцны хангамж хүрэлцэхүйц болж аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр хангагдана. 3. ТХЗ 9: Хүн бүрд тэгш, хүртээмжтэй, эдийн засгийн хөгжил, хүний сайн сайхан аж байдлыг дэмжих, чанартай, найдвартай, тогтвортой, уян хатан дэд бүтэц бий болж буй хэлбэр тул ТХЗ 9-ийг хангаж байна. 4: ТХЗ 8: Эрчим хүчний станцын өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэх явцад ажлын байр бий болох бөгөөд өргөтгөл ашиглалтад орсны дараа ажлын байр нэмэгдэх боломжтой.	1. Сэргээгдэх эрчим хүчээр үүсгэгдсэн цахилгаан эрчим хүчийг иргэдэд хүргэж байгаа тул МУ-ын ТХЗ-д чиглэгдсэн үйл ажиллагаа юм. 2. Нүүрсний эх үүсвэртэй цахилгаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр сольж байгаа тул байгаль орчинд эерэг нөлөөтэй. 3. Тухайн цахилгааны шугамыг татах төслийг хэрэгжүүлэх ажилчид болон станцын ажилчдын хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх нийгэм, эдийн засгийн эерэг нөлөөтэй.	1. Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал МВт/кВт.ц 2. Хүлэмжийн хийн ялгаралтын бууралт (tCO₂e), Бууруулсан хүлэмжийн хийн ялгарлын хувь 3. Сэргээгдэх эрчим хүчний нийт цахилгаан эрчим хүчинд эзлэх хувь 4. Шинээр эрчим хүчинд холбогдсон өрхийн тоо 5. Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын нийт хүн амд эзлэх хувь
---	---	---	---------------	--	---	--

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

5.3 Үр шим хүртэгч

Зардал, төсөл, арга хэмжээний үр шимийг хүртэгч гэдэг нь тухайн төслийг хэрэгжүүлснээр давуу тал, үр өгөөж, эерэг үр дүнг шууд хүртдэг хувь хүн, бүлэг, хамт олныг хэлнэ. Төслийн үр шим нь үйлчилгээ, дэд бүтэц, эдийн засгийн боломж, нийгмийн хөгжил эсвэл иргэдийн сайн сайхан амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн эерэг нөлөөллийн хэлбэртэй байж болно.

Салбар бүрд, зардал, төсөл, арга хэмжээ бүрд үр шим хүртэгч нь харилцан адилгүй өөр байдаг. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар дах үр шим хүртэгч нь төсвийн зардлыг тооцоход ашиглагддаг тул үр шим хүртэгчийг тодорхойлоход илүү хялбар байна. Тухайлбал, цэцэрлэг сургуульд хамрагдаж байгаа хүүхдийн тоо, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо, хүүхдийн мөнгөнд хамрагдаж буй хүүхдийн тоо нь үр шим хүртэгч юм. Харин хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт үр шим хүртэгчийг тодорхойлоход хүндрэлтэй. Жишээ нь, мал эмнэлгийн вакцины зардлыг тооцохдоо малын тоо толгойг нэгж үнээр нь үржүүлэн гаргадаг боловч эцсийн үр шим хүртэгч нь тухайн малын эзэд буюу малчид юм. Гэтэл малаа вакцинд хамруулсан малчдын тоог тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Иймд, төсвийн төсөл боловсруулахдаа үр шим хүртэгчийг тодорхойлсон байх шаардлагатай буюу малаа вакцинуулалтад хамруулсан малчдын тоон мэдээллийг тодорхой тусгах шаардлагатай. Соёлын

салбарын хувьд үр шим хүртэгч нь тодорхой боловч төсвийн байгууллага, засаг захиргааны нэгжээр нарийвчлан гаргасан статистик мэдээлэл хангалтгүй байна.

Эрчим хүчний салбарын жишээнд Дундговь аймгийн Сайнцагаан сумын иргэд болон Говь-Алтай аймгийн Алтай хотын иргэдийг санал болгож буй төслийн үр шим хүртэгчид гэж үзэж, тухайн сум болон аймгийн төвийн иргэдийн тоог үр шим хүртэгчдийн тоо гэж авна.

Хүснэгт 8. Үр шим хүртэгч

Үр шим хүртэгч		
#	Үр шим хүртэгчийн тодорхойлолт	Үр шим хүртэгчийн тоо
1	Дундговь аймгийн Сайнцагаан сумын иргэд	15,957
2	Говь-Алтай аймгийн Алтай хотын иргэд	19,074

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

5.4 ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн түвшин

Саналын маягтын энэ хэсэгт ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн биелэлт болон цаашдын чиг хандлага, мөн тухайн зардал, төсөл, арга хэмжээний төрлийг тодорхойлж бичнэ. Монгол Улсын хувьд ТХЗ-ын үзүүлэлт хоцрогдолтой байгаа салбарт хувь нэмэр оруулах төсөлд ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулж, уг ТХЗ-ын үзүүлэлтээ сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор уг олон улсад нийтэлдэг үзүүлэлтийг энэхүү зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгоход харгалзана.

“ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн биелэлт” -ийг улс орнууд жил бүр тайлагнадаг ба энэхүү тайланг олон улсын хөндлөнгийн байгууллага баталгаажуулдаг². Энэхүү баталгаажуулсан тайланд тухайн орны ТХЗ бүрийн өнөөгийн байдал (SDG achievement) болон цаашдын чиг хандлага (SDG Trend)-ыг тус бүр 4 төрөлд хуваан үзүүлдэг. Уг тайлангаас ТХЗ-ын биелэлт болон чиг хандлагын үнэлгээг авч тавихдаа саналын маягтын өмнөх хэсэгт бөглөсөн “Үндсэн ТХЗ”-ын харгалзах үзүүлэлтийг авч үзнэ. Хүснэгт 8-д дурдсан жишээнүүд адил салбар (Эрчим хүчний салбар)-г хамаарах тул үндсэн ТХЗ-ын өнөөгийн байдал болон чиг хандлага нь адил түвшинд байна.

“Зардал, төсөл, арга хэмжээний төрөл” - ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдсанаар дараах зардлуудыг ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлж болох зардлуудад тооцно гэж үзсэн байна. Үүнд:

Хөрөнгө оруулалтын зардал: Капиталын хөрөнгө оруулалт, үүнд барилга байгууламж, дэд бүтэц, сүлжээ, үйлдвэрийн үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж эсвэл биет хөрөнгө

Татаас, тусламж, зээл: Хүн амын нийгмийн суурь хангамж үйлчилгээг хангах зорилгоор буцалтгүй тусламж эсхүл хөнгөлөлттэй зээл хэлбэрээр үзүүлэх санхүүгийн хөнгөлөлт, урамшуулал.

Татварын зардал: Нийгэм, байгаль орчны зорилтуудыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг дэмжих зорилгоор үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлт.

Үйл ажиллагааны зардлууд: Төрийн үйлчилгээг үзүүлэх, нийтийн бараа бүтээгдэхүүнээр хангахад чиглэсэн Засгийн газраас гаргасан зардал. Эдгээр зардлууд нь хүлээн зөвшөөрөгдөх төслүүдтэй холбоотой шууд зардлаар хязгаарлагдана.

² Тогтвортой хөгжлийн 2023 оны тайлан: <https://sdgtransformationcenter.org/reports/sustainable-development-report-2023>

Интервенцийн зардлууд: Засгийн газраас өөрийн харьяа төрийн болон төрийн өмчит байгууллагуудад шилжүүлэх шилжүүлэг.

Жишээ болгон авсан 2 төсөл нь “хөрөнгө оруулалтын зардал” төрөлд хамаарч байна.

Хүснэгт 9. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн түвшин

ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн түвшин				
#	Төслийн нэр	ТХЗ өнөөгийн байдал	ТХЗ чиг хандлага (trend)	Зардал, төсөл, арга хэмжээ хуваарилалт
1	Аймгийн төвийн 220/110/35 кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/	Томоохон сорилтууд хэвээр байна (Major challenges remain)	Зогсонги байдалд байна (Score stagnating)	Хөрөнгө оруулалтын зардал
2	Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/	Томоохон сорилтууд хэвээр байна (Major challenges remain)	Зогсонги байдалд байна (Score stagnating)	Хөрөнгө оруулалтын зардал

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

5.5 Байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Санал болгож буй зардал, төсөл, арга хэмжээ нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн гэсэн 3 төрөлд сөрөг нөлөөлөл үзүүлэх эсэхийг тодорхойлох шаардлагатай. Хэрэв тухайн төслийг хэрэгжүүлэхэд гарч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсвэл авч хэрэгжүүлж байгаа бол харгалзах хэсэгт тайлбарлан бичнэ. Төсөл 3 төрлийн сөрөг нөлөөг бүгдийг үзүүлдэг байж болно.

Эхний жишээ нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй байгааг тайлбарлан бичсэн байна. Харин хоёр дахь жишээг сөрөг нөлөөгүй гэж үзсэн байна.

Хүснэгт 10. Байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл		
#	Төслийн нэр	Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн сөрөг үр нөлөө байгаа эсэх? Тухайлбал, ойн устгал, биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлөх, иргэдийг нүүлгэн шилжүүлэх гэх мэт.
1	Аймгийн төвийн 220/110/35 кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/	Уг төсөл хэдий дэд станцын төсөл боловч цахилгааны эх үүсвэр нь нүүрс тул хүлэмжийн хий ялгаруулдаг. Тиймээс байгаль орчинд сөрөг нөлөөлөлтэй ангилалд орж байна.
2	Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/	Сөрөг нөлөө байхгүй.

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

Дараагийн шатанд уг жагсаалтад багтсан зардал, төсөл, арга хэмжээ тус бүр дээр оноо өгөх байдлаар үнэлгээ хийж, 80-аас дээш оноо авсан зардал, төсөл, арга хэмжээг эцсийн шатанд сонгож авна. Төслийн оноо өгч үнэлгээ хийх, сонгох ажлыг дараагийн хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

6. Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох

Салбарын яамнууд Тогтвортой Хөгжлийн Зорилгыг хангахад чиглэсэн боломжит төслүүдийг тодорхойлж **зардал, төсөл, арга хэмжээний саналын маягтыг** Сангийн яаманд ирүүлнэ. Сангийн яам нь санхүүжүүлэх төслийн шаардлага хангаж буй эсэхийг хавсралтад тусгасан **онооны хүснэгтийн** дагуу үнэлж, сонгон шалгаруулна. Шалгарсан төслүүдийг Засгийн газар хэлэлцэж, эцсийн шийдвэрийг гаргаж, санхүүжүүлэх төслүүдийг батална.

Зардал, төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах онооны хүснэгт нь нийт 100 оноотой байх ба дараах 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. 80 ба түүнээс дээш оноо авсан зардал, төсөл, арга хэмжээг ТХЗНБ-оор санхүүжүүлэх боломжтой гэж үзнэ.

1. Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл нь нийт 28 оноо;
2. ТХЗ-ын нөлөөллийн хэсэг нь нийт 40 оноо;
3. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн түвшин нь нийт 32 оноо;
4. Зардал, төсөл, арга хэмжээний ТХЗ-д үзүүлэх байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг нийт “-30” хүртэлх оноогоор тус тус үнэлнэ.

6.1 Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл (нийт 28 хүртэл оноо)

Салбарын яамдын ирүүлсэн зардал, төсөл, арга хэмжээний санал болон дагалдах бусад баримт бичиг дээр үндэслэн дараах гурван асуултаас бүрдэх онооны хүснэгтийн эхний бүрэлдэхүүн “Төслийн ерөнхий мэдээлэл” хэсгийг үнэлнэ.

- **Зардал, төсөл, арга хэмжээний баримт бичиг** нь төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, засгийн газрын тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагч болон төслийн зохицуулагчийн мэдээллийг бүрэн тусгасан байвал 10 оноо, хэсэгчлэн тусгасан байвал 5 оноо, огт тусгаагүй бол 0 оноо гэсэн үнэлгээг тус тус өгнө.
- **Зардал, төсөл, арга хэмжээний төсөв** гэсэн хэсэгт барилга угсралтын гүйцэтгэлийн хугацаа эсвэл хэрэгжүүлэх хугацааг тодорхой тусгасан байдлыг үнэлнэ. Зардал, төсөл, арга хэмжээний хугацаа бүрэн тодорхойлогдсон бол 10 оноо, хэсэгчлэн тодорхойлсон бол 5 оноо, тодорхойлоогүй бол 0 оноогоор үнэлнэ.
- **ТХЗНБ-оор санхүүжүүлэхийг хүсэж буй мөнгөн дүн** нь зардал, төсөл, арга хэмжээг дуусгахад хүрэлцэх эсэх эсвэл цаашид хэрэгжүүлэхэд нэмэлт санхүүжилт шаардагдах эсэхийг харгалзана. ТХЗНБ-ын хуваарилах мөнгөн дүн нь зардал, төсөл, арга хэмжээг дуусгахад хүрэлцээтэй бол 8 оноо, хүрэлцэхгүй нэмэлт санхүүжилт шаардлагатай бол 4 оноогоор үнэлнэ.

Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээллийн хэсгийг үнэлэхэд төслийн санал өгөх маягтаас гадна дараах төсөв, санхүүгийн бодлогын баримт бичигт туссан шалгуурыг хангасан эсэхийг харгалзан үзнэ.

- Хөрөнгө оруулалтын зардал нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын шаардлагыг хангасан байна.
- Зардал, төсөл, арга хэмжээний урсгал зардал нь төлөвлөгөө, үр дүн болон шалгуур үзүүлэлтийг тусгасан холбогдох баримт бичгээр баталгаажсан байна. Мөн төсвийн тухай хууль болон холбогдох хууль журамтай нийцсэн байх ёстой.

Дараах хүснэгтийн дагуу зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээллийг үнэлнэ.

Хүснэгт 11. Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээллийн үнэлгээ

Зардал, төсөл, арга хэмжээний нэр	Нийт санхүүжилт (сая. төгрөг)	1. Зардал, төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл		
		Зардал, төсөл, арга хэмжээний баримт бичиг нь төлөвлөгөө, засгийн газрын тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагч болон төслийн зохицуулагчийг тусгасан эсэх?	Зардал, төсөл, арга хэмжээний төсөв, барилга угсралтын гүйцэтгэлийн хугацаа эсвэл хэрэгжүүлэх хугацааг тодорхойлсон эсэх?	ТХЗНБ-оор санхүүжүүлэхийг хүссэн мөнгөн дүн нь зардал, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дуусахад хүрэлцэх эсэх? эсвэл цаашид хэрэгжүүлэхэд нэмэлт санхүүжилт шаардлагатай эсэх?
		Бүрэн тусгасан (10) Хэсэгчлэн тусгасан (5), тусгаагүй (0)	Бүрэн тодорхойлсон (10) Хэсэгчлэн тодорхойлсон (5), тодорхойлоогүй (0)	Нэмэлт санхүүжилт шаардлагагүй (8), Нэмэлт санхүүжилт шаардлагатай (4)
Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/	11,294.7	10	10	8
Аймгийн төвийн 220/110/35 кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/	478.4	10	10	8

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

Тухайлбал дээрх жишээнд дурдсан “Аймгийн төвийн 220/110/35 кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/”, “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/” төслүүд нь эрчим хүчний хөрөнгө оруулалтын төслүүд бөгөөд санал авах маягт, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын дагуу холбогдох баримт бичиг, техник эдийн засгийн үнэлгээг бүрэн хангаж улсын төсөвт батлагдсан учир эхний асуултад **10 оноо** гэсэн үнэлгээг өгнө.

“Аймгийн төвийн 220/110/35 кВ Мандал дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/” төсөл нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ээс 2023 оны 12 дугаар сарын 31-ны хооронд буюу 3 жилийн хугацаанд бүрэн хэрэгжиж дуусахаар байна. Энэ нь ТХЗНБ-ийн хугацаанд бүрэн дуусаж үр нөлөөг хэмжих боломжтой учир бүтэн **10 оноо** гэсэн үнэлгээг өгнө. Харин “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станцын” төсөл нь 2019 оны 1 дүгээр сарын 1-ээс 2024 оны 12 дугаар сарын 31-ны хооронд буюу 5 жилийн хугацаанд бүрэн хэрэгжиж дуусна. Зорилтот хүн ам сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт холбогдох, үр нөлөөг үнэлэх, тайлагнах боломжтой тул нийт **10 онооны** үнэлгээг өгнө.

Жишээгээр үзүүлсэн 2 төслийг хэрэгжүүлэхэд нэмэлт санхүүжилт шаардлагагүй бөгөөд хөрөнгө оруулалт нь хангалттай гэж үзэн тус бүр **8 оноо** өгөв.

6.2 ТХЗ-ын нөлөөлөл (нийт 40 хүртэл оноо)

ТХЗ-ын нөлөөллийн хэсгийг ТХЗ-д оруулах хувь нэмэр, 1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоо (зорилтот хүн амын тоо) гэсэн хоёр шалгуураар үнэлнэ. Сангийн яам нь тухайн зардал, төсөл, арга хэмжээний санал авах маягтад тусгагдсан “үндсэн ТХЗ”, “шууд бусаар нөлөөлөх ТХЗ”, “үр шим хүртэгчдийн тоо” гэсэн баганууд дээрх мэдээллүүдийг ашиглана.

Хүснэгт 12. ТХЗ-ын нөлөөллийг үнэлэх

	2. ТХЗ-ын нөлөөлөл	
Зардал, төсөл, арга хэмжээний нэр	Төсөл нь олон ТХЗ-д хувь нэмэр оруулж байгаа юу? (ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдсан)	Үр шимт хүртэгч (1 сая төгрөгт ноогдох зорилтот хүн амын тоо/Үр шимт хүртэгчдийн тоо)
	5-аас дээш ТХЗ-д хувь нэмэр оруулж байгаа (20), 2-оос 5 ТХЗ-д хувь нэмэр оруулж байгаа (10), 1 ТХЗ-д хувь нэмэр оруулж байгаа (5)	75 дахь интервалын хэмжээнээс их (персентил) (20), 75-с бага 50 дахь интервалын хэмжээнээс их (персентил) (10), 50-с бага 25 дахь интервалын хэмжээнээс их (персентил) (5), 25 дахь интервалын хэмжээнээс бага (персентил) (0)
Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/	10	5
Аймгийн төвийн 220/110/35 кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/	10	20

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

1. Эерэг хувь нэмэр оруулж буй ТХЗ-ын тоо

Зардал, төсөл, арга хэмжээ нь хэд хэдэн ТХЗ-д зэрэг хувь нэмэр оруулж болох бөгөөд эергээр хувь нэмэр оруулж буй ТХЗ-ын тоог үнэлгээний энэ хэсэгт ашиглана.

- Хэрэв төсөл нь 5-аас дээш ТХЗ-д эерэг хувь нэмэр оруулж байгаа бол 20 оноо;
- Хэрэв төсөл нь 2-оос 5 хүртэлх ТХЗ-д эерэг хувь нэмэр оруулж байгаа бол 10 оноо;
- Хэрэв төсөл нь зөвхөн 1 ТХЗ-д эерэг хувь нэмэр оруулж байгаа бол 5 оноо гэсэн үнэлгээг тус тус өгнө.

Дээр дурдсан 2 төсөл нь “ТХЗ 7 - Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх” -д шууд хувь нэмэр оруулж, “ТХЗ 11-Ээлтэй хот, иргэдийн оролцоо”, “ТХЗ 9-Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх”, “ТХЗ 8-Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих” -д шууд бусаар хувь нэмэр оруулж байна. Хоёр төсөл нь нийт 4 ТХЗ-д шууд болон шууд бусаар хувь нэмэр оруулж байгаа тул 10 оноогоор үнэлэгдсэн.

2. 1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн (зорилтот хүн амын) тоон үзүүлэлт

Нэг сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоон үзүүлэлт нь хуваарилагдсан төсөв нь хэрхэн үр ашигтай зарцуулагдаж буйг илэрхийлж байгаа үзүүлэлт юм.

Зардал, төсөл, арга хэмжээний үр шимийг хүртэгч гэдэг нь тухайн төслийг хэрэгжүүлснээр давуу тал, үр өгөөж, эерэг үр дүнг шууд хүртдэг хувь хүн, бүлэг, хамт олныг хэлнэ. Төслийн үр шим нь үйлчилгээ, дэд бүтэц, эдийн засгийн боломж, нийгмийн хөгжил эсвэл иргэдийн сайн сайхан амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн эерэг нөлөөллийн хэлбэртэй байж болно.

1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоон үзүүлэлтийг тооцохдоо зардал, төсөл, арга хэмжээний саналын маягтад илгээсэн төслийн үр шим хүртэгчдийн тоог санхүүжилтийн дүнд (сая төгрөгөөр) хувааж тооцно.

1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоон үзүүлэлтийг тооцож оноо өгөхөд харьцуулах жишиг үзүүлэлт (benchmark) байхгүй тул саналын маягтаар ирүүлсэн зардал, төсөл, арга хэмжээний тоон үзүүлэлтээр өгөгдлийн багц үүсгэн, уг багцыг 75, 50, 25 дахь интервал (percentile)-д хувааж оноо өгнө.

ТХЗНБ-ын баримт бичигт тусгагдсан салбар болон зардлын ангилал (хөрөнгө оруулалт, урсгал зардал) тус бүрд хамаарагдах төслүүдийн 1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоон үзүүлэлтээс бүрдсэн өгөгдлийн багцын 75, 50, 25 дахь интервалыг (percentile) тодорхойлно. Зардал, төсөл, арга хэмжээний 1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоон үзүүлэлтийг салбар, зардлын ангилал бүрээр тооцсон 75, 50, 25 дахь интервалын (percentile) утгатай харьцуулан дараах байдлаар үнэлж оноо өгнө.

Хэрэв үзүүлэлт нь 75 дахь интервалаас их байвал 20 оноо, 75-аас 50 дахь интервалын хооронд байвал 10 оноо, 50-аас 25 дахь интервалын хооронд байвал 5 оноо, харин 25 дахь интервалаас бага бол 0 оноог тус тус авна.

Салбар бүрд хамаарах зардал, төсөл, арга хэмжээний 1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоон үзүүлэлтүүдийн өгөгдлийн багцын 75, 50, 25 дахь интервалыг дараах эксел (Microsoft Excel) томъёогоор тооцно.

=PERCENTILE(өгөгдлийн багц, 0.75)

Монгол Улсын 2023 оны төсөвт тусгагдсан бондоор санхүүжих боломжтой эрчим хүчний төслүүдийг дээрх томъёогоор Microsoft Excel программыг тооцсон 75, 50, 25 дахь утгын хувь хэмжээг дараах зургаас харна уу.

Зураг 3. Сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний хэмнэлт ангиллын жишиг

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

Харин “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/” төслийн 1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоон үзүүлэлт нь үр шим хүртэгчид болох Говь-Алтай аймгийн Алтай хотын хүн амын тоо болох 19,000-ыг шаардлагатай санхүүжилт болох 11,294.7 сая төгрөгт хувааснаар 1.68 гарч байна. Энэхүү тоон үзүүлэлт нь 50-аас 25 дахь интервалын хооронд байгаа тул "5 оноо" гэсэн үнэлгээг өгсөн.

Төслийн дугаар	Шаардлагатай санхүүжилт (сая төгрөгөөр)	Үр шим хүртэгчд ийн тоо	1 сая төгрөг тутамд ноогдох үр шим хүртэгчдийн тоо	Зөвшөөрөгдөх салбар, зардлын ангилал бүрээр тодорхойлсон 75, 50, 25 дахь интервал хэмжээ	Нийт оноо
#	A	Б	B=B/A	Г	Д
1	478.4	15,957	15,957/478.4=33.35	21.30-с дээш (20) 6.17-с дээш 21.30-с бага (10) 1.29-с дээш 6.17-с бага (5) 1.29-с доош (0)	20
2	11,294.7	19,000	19,000/11,294.7=1.69	21.30-с дээш (20) 6.17-с дээш 21.30-с бага (10) 1.29-с дээш 6.17-с бага (5) 1.29-с доош (0)	5

Эх сурвалж: Сангийн яам, Төслийн зөвлөхүүд

28

төгрөгт ногдох үр шим хүртэгчдийн тоог персентил ашиглан эрэмбэлж зардал, төсөл, арга хэмжээг сонгоход ТХЗ, ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлттэй нийцсэн байгаль орчин, нийгэм, эдийн засагт эерэг нөлөөтэй, чухал ач холбогдолтой зардал, төсөл, арга хэмжээ хасагдах эрсдэлтэй байгааг дээрх жишээнээс харж болохоор байна.

Тиймээс 1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоон үзүүлэлтийн хэсэгт оноо өгөхдөө Сангийн Яам нь салбарын яамтай зөвшилцөн Монгол Улсын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг харгалзан үзэж 20 хүртэлх оноог өгөх боломжтой. Мөн тухайн нөхцөл байдлаас шалтгаалан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, илүү оновчтой бөгөөд хялбар аргыг ашиглаж болох юм.

6.3 ТХЗ-ийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийн түвшин (нийт 32 хүртэл оноо)

2015 онд ТХЗ-ыг баталснаас хойш³ ТХЗ-ын өнөөгийн байдал болон чиг хандлага гэсэн 2 үзүүлэлтийг харуулдаг бөгөөд ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн түвшинд үндэслэн үнэлсэн байдаг.

ТХЗ нь 169 зорилттой ба ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэх 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байдаг боловч үнэлгээг өгөхдөө зөвхөн 17 ТХЗ-ын үнэлгээг авч үзнэ.

Үнэлгээг ТХЗ-ын өнөөгийн байдал болон ТХЗ-ын чиг хандлага гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгт хуваан үнэлнэ. Бүрэлдэхүүн хэсэг бүр хамгийн ихдээ 16 оноогоор үнэлэгдэх ба энэ хэсэгт нийт 32 оноо авах боломжтой. Зардал, төсөл, арга хэмжээний ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн биелэлтийг үнэлэхдээ саналын маягтад тусгасан “үндсэн ТХЗ”-ыг авч үзнэ.

Онооны хүснэгтийн энэ хэсэг нь ТХЗ-ын биелэлт сайтай байгаа салбарын төсөл бага оноо авч, биелэлт хангалтгүй байгаа салбарын төсөл өндөр оноо авахаар загварчлагдсан байна.

Зураг 4. Монгол Улсын 2023 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн хураангуй



Эх сурвалж: Тогтвортой Хөгжлийн 2023 оны тайлан

1. Зардал, төсөл, арга хэмжээний ТХЗ-ын өнөөгийн байдлыг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлт нь:

³ Тогтвортой хөгжлийн 2023 оны тайлан: <https://sdgtransformationcenter.org/reports/sustainable-development-report-2023>

- *ТХЗ биелсэн:* Амжилттай биелсэн ТХЗ-д эерэг хувь нэмэр оруулах салбарын зардал, төсөл, арга хэмжээ 4 оноо авна.

- *Цөөн сорилтууд хэвээр байна:* Биелээгүй, цөөн тооны сорилтууд хэвээр байгаа ТХЗ-д хувь нэмэр оруулж байгаа салбарын зардал, төсөл, арга хэмжээ 8 оноо авна. Зорилгодоо бүрэн хүрэхийн тулд тасралтгүй хүчин чармайлт гаргах шаардлагатай.

- *Зарим сорилтууд хэвээр байна:* Биелээгүй, зарим сорилтууд хэвээр байгаа ТХЗ-д хувь нэмэр оруулж байгаа салбарын зардал, төсөл, арга хэмжээ 12 оноо авна. Эдгээр бэрхшээлийг даван туулахын тулд ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатай.

- *Томоохон сорилтууд хэвээр байна:* Биелээгүй, томоохон сорилтууд хэвээр байгаа ТХЗ-д хувь нэмэр оруулж байгаа салбарын зардал, төсөл, арга хэмжээ 16 оноо авна. Томоохон сорилтууд хэвээр байгаа ТХЗ-ын чухал асуудлуудыг шийдвэрлэхийн тулд өргөн хүрээтэй арга хэмжээ авах шаардлагатай.

2. Зардал, төсөл, арга хэмжээний ТХЗ-ын чиг хандлагыг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлт нь:

- *Хэвийн хэрэгжиж байгаа:* Амжилттай хэрэгжиж байгаа ба ТХЗ-д оруулах хувь нэмрийг хадгалах эсвэл цаашид сайжруулах чиглэлд явж байгаа салбарын зардал, төсөл, арга хэмжээ 4 оноо авна.

- *Сайжирч байгаа:* ТХЗ-ын гол шалгуур үзүүлэлтүүд сайжирч байгаа салбарын зардал, төсөл, арга хэмжээ 8 оноо авна.

- *Зогсонги байдалтай байгаа:* ТХЗ-д үзүүлэх нөлөөлөл буурсан, дорвитой ахиц дэвшил, сайжруулалт дутмаг байгаа салбарын зардал, төсөл, арга хэмжээ 12 оноо авна.

- *Буурах хандлагатай байгаа:* ТХЗ-ын үзүүлэлт нь буурч байгаа болон чухал анхаарал хандуулах шаардлагатай байгаа салбарын зардал, төсөл, арга хэмжээ нь 16 оноо авна.

Өмнөх хэсэгт авсан жишээнд үндэслэн ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн түвшнийг үнэлж үзлээ.

- “Аймгийн төвийн 220/110/35 кВ Мандал дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/” төсөл нь “ТХЗ 7”-д хамаарч байгаа бөгөөд уг ТХЗ-ын биелэлтийн түвшин “Томоохон сорилтууд хэвээр байгаа” гэж ангилагдаж байгаа тул 16 оноо, ТХЗ-ын чиг хандлага нь “зогсонги байдалтай байгаа” гэж ангилагдаж байгаа тул 12 оноо авна.
- “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/” төсөл нь “ТХЗ 7”-д хамаарч байгаа бөгөөд уг ТХЗ-ын биелэлтийн түвшин “Томоохон сорилтууд хэвээр байгаа” гэж ангилагдаж байгаа тул 16 оноо, ТХЗ-ын чиг хандлага нь “зогсонги байдалтай байгаа” гэж ангилагдаж байгаа тул 12 оноо авна.

ТХЗ 17 зорилгын биелэлтийн түвшний үзүүлэлтээр харахад өнөөгийн байдал болон чиг хандлагын үнэлгээ нь өөр өөр үнэлгээтэй шалгуур үзүүлэлтийн дунджаар хэт ерөнхий байдлаар гарч байна. Жишээлбэл, Эрчим хүчний салбарын “ТХЗ 7”-ын биелэлт нь улаан буюу “томоохон сорилтууд хэвээр байна” гэж үнэлэгдэж байгаа бол “ТХЗ 7”-ын шалгуур үзүүлэлт “7.1.1 - Эрчим хүчинд холбогдсон айл өрхийн тоо” ногоон буюу биелсэн төлөвтэй байна.

6.4 Байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл (нийт “-30” хүртэл оноо)

Зардал, төсөл, арга хэмжээ нь байгаль орчин, нийгэм, эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа бол тус бүр “-10” хүртэлх оноогоор үнэлэгдэнэ.

Тухай зардал, төсөл, арга хэмжээний байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн тохиолдолд сөрөг нөлөөллийг харгалзан үзэж оноог 0, -5 хүртэл багасгах боломжтой.

1. Зардал, төсөл, арга хэмжээний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэх

Хэрэгжүүлж буй зардал, төсөл, арга хэмжээ нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх үү? (Жишээ нь, хүлэмжийн хий ялгаруулж байгаа эсэх? тухайн төсөл нь ой модыг устгах эсэх? г.м.)

Үнэлгээний шалгуур:

- *Сөрөг нөлөөгүй:* Зардал, төсөл, арга хэмжээ нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй бол 0 оноо авна.
- *Бага зэргийн сөрөг нөлөөлөл:* Байгаль орчинд бага зэргийн сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа бол -5 оноо авна.
- *Их хэмжээний сөрөг нөлөөлөл:* Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл их бол -10 оноо авна.

Жишээ нь, шинэ сургуулийн барилгын дулааны эрчим хүчний эх үүсвэр нь нүүрс бол бол энэ төсөл байгаль орчинд бага зэргийн сөрөг нөлөөтэй гэж үзэж “-5” оноо өгнө. Хэрэв тухайн сургуулийн дулааны эрчим хүчний эх үүсвэр нь сэргээгдэх эрчим хүч бол байгальд сөрөг нөлөөгүй гэж үзэн “0” оноо өгнө.

2. Зардал, төсөл, арга хэмжээний нийгэм, хүн амд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэх

Нийгэм, хүн амд сөрөг нөлөөлөл үзүүлэх үү? (Жишээ нь, тухайн төсөл хэрэгжсэнээр тухайн бүсэд амьдарч буй хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх эсэх?, орон нутгийн бизнест сөрөг нөлөө үзүүлэх эсэх? г.м.)

Үнэлгээний шалгуур:

- *Сөрөг нөлөөгүй:* Зардал, төсөл, арга хэмжээ нь нийгэм, хүн амд сөрөг нөлөөгүй бол 0 оноо авна.
- *Бага зэргийн сөрөг нөлөөлөл:* Нийгэм, хүн амд бага зэргийн сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа бол -5 оноо авна.
- *Их хэмжээний сөрөг нөлөөлөл:* Нийгэм, хүн амд сөрөг нөлөөлөл их бол -10 оноо авна.

Жишээ нь, усан цахилгаан станц барих төсөл нь байгаль орчинд ээлтэй, сэргээгдэх эрчим хүчний төсөл юм. Гэвч уг төсөл нь томоохон газар нутгийг хамаарах тул ард иргэдийг нүүлгэн шилжүүлэх, тухайн бүсэд байрлах барилга, байгууламжийг нураах шаардлага бий болдог бөгөөд нөхөн төлбөр олгох асуудал гарна. Энэхүү төсөл нь нийгэм, хүн амд их хэмжээний сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа тул “-10” оноо өгнө. Хэрэв эдгээр сөрөг нөлөөг хангалттай хэмжээнд бууруулах, арилгах арга хэмжээ авсан тохиолдолд “0” хүртэлх оноо болгон бууруулах боломжтой.

3. Зардал, төсөл, арга хэмжээний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлэх

Эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлэх үү? (Уг төсөл нь жендерийн тэгш бус байдлыг бий болгож байгаа эсэх? Ажилгүйдлийг бий болгож байгаа эсэх? г.м)

Үнэлгээний шалгуур:

- *Сөрөг нөлөөгүй:* Зардал, төсөл, арга хэмжээ нь эдийн засагт сөрөг нөлөөгүй бол 0 оноо авна.
- *Бага зэргийн сөрөг нөлөөлөл:* Эдийн засагт бага зэргийн сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа бол -5 оноо авна.
- *Их хэмжээний сөрөг нөлөөлөл:* Эдийн засагт сөрөг нөлөөлөл их бол -10 оноо авна.

Жишээ нь, гэр хорооллын дахин төлөвлөлт хийх төслийн хувьд тухайн дүүрэг, хороонд үйл ажиллагаа явуулж буй бичил бизнесүүдийг нүүлгэн дахин төлөвлөх шаардлагатай болно. Тиймээс уг төсөл иргэдийн эдийн засгийн хувьд сөрөг нөлөө үзүүлж байна гэж үзэн “-5” оноо авна. Хэрэв нөхөн төлбөр олгох гэх мэт аргаар сөрөг нөлөөллийг хангалттай хэмжээнд бууруулах, арилгах арга хэмжээ авбал “0” хүртэлх оноо болгон бууруулах боломжтой.

Тус баримт бичгийн өмнөх хэсгүүдэд авсан жишээнүүдийн байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлбэл:

- “Аймгийн төвийн 220/110/35 кВ Мандал дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/” төсөл нь эрчим хүчний эх үүсвэр нь нүүрсээр ажилладаг цахилгаан станц тул байгаль орчинд бага зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлэх тул “-5” оноогоор үнэлэгдсэн.
- “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/” төсөл нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд сөрөг нөлөөлөл байхгүй тул “0” оноо өгнө.

Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийн үнэлгээг нийт онооноос хасаж тооцно.

Энэ аргачлалын дагуу өмнөх хэсгүүдэд жишээгээр дурдсан 2 төслийн оноог Хүснэгт 14-т үзүүлэв. Онооны хүснэгтээс харахад “Аймгийн төвийн 220/110/35 кВ Мандал дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/” төсөл нь нийт 81 оноо авч ТХЗ-той нийцсэн бондоор санхүүжүүлэх боломжтой гэж үнэлэгдсэн. Харин “Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/” төсөл нь нийт 71 оноо авч ТХЗ-той нийцсэн бондоор санхүүжүүлэх боломжгүй гэж үнэлэгдсэн. Энэ 2 төслийг шинжилж үзэхэд “1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоон үзүүлэлт”-ээр оноо зөрүү хамгийн их болсон байна. Эдгээр төслүүдийн үр шим хүртэгчдийн тоо нь ойролцоо боловч “Аймгийн төвийн 220/110/35 кВ Мандал дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/” төсөл нь бага төсөвтэй тул өндөр оноо авч улмаар шалгарсан байна.

Хүснэгт 14. Зардал, төсөл, арга хэмжээний үнэлэх сонгох онооны хүснэгт

Бүрэлдэхүүн хэсэг	Асуулт	Үнэлгээний шалгуур	“Аймгийн төвийн 220/110/35 кВ Мандал дэд станцын өргөтгөлийн ажил	“Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын
-------------------	--------	--------------------	---	---

			/Дундговь, Сайнцагаан сүм/	ЦДАШ, дэд станц /Говь- Алтай/
1. Зардал төсөл арга хэмжээний ерөнхий мэдээлэл	Зардал, төсөл, арга хэмжээний баримт бичиг нь төлөвлөгөө, засгийн газрын тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагч болон төслийн зохицуулагчийн мэдээллийг бүрэн тусгасан эсэх?	Бүрэн тусгасан (10) Хэсэгчлэн тусгасан (5), огт тусгаагүй (0)	10	10
	Зардал, төсөл, арга хэмжээний төсөв нь барилга угсралтын гүйцэтгэлийн хугацаа эсвэл хэрэгжүүлэх хугацааг тодорхой тусгасан байдлыг үнэлнэ. Зардал, төсөл, арга хэмжээний хугацаа бүрэн тодорхойлогдсон эсэх?	Бүрэн тодорхойлсон (10) Хэсэгчлэн тодорхойлсон (5), тодорхойлоогүй (0)	10	10
	ТХЗНБ-оор санхүүжүүлэхийг хүсэж буй мөнгөн дүн нь зардал, төсөл, арга хэмжээг дуусгахад хүрэлцэх эсэх эсвэл цаашид хэрэгжүүлэхэд нэмэлт санхүүжилт шаардагдах эсэх?	Зардал, төсөл, арга хэмжээг дуусгахад хүрэлцээтэй (8), Хүрэлцэхгүй нэмэлт санхүүжилт шаардлагатай (4)	8	8
		Нийт	28	28
2. ТХЗ-ын нөлөөлөл	Төсөл нь олон ТХЗ-т хувь нэмэр оруулж байгаа юу? (Баримт бичигт тусгагдсан)	5 аас дээш ТХЗ-д хувь нэмэр оруулж байгаа (20), 2-оос 5 ТХЗ-д хувь нэмэр оруулж байгаа (10), 1 ТХЗ-д хувь нэмэр оруулж байгаа (5)	10	10
	Зорилтот хүн амын тоо/Үр шимт хүртэгч (1 сая төгрөгт ноогдох зорилтот хүн амын тоо/Үр шимт хүртэгчдийн тоо)	75 дахь интервалын хэмжээнээс их (персентил) (20), 75-с бага 50 дахь интервалын хэмжээнээс их (персентил) (10), 50-с бага 25 дахь интервалын хэмжээнээс их (персентил) (5), 25 дахь интервалын хэмжээнээс бага (персентил) (0)	20	5
		Нийт	30	15
3. ТХЗ-ийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийн түвшин	Зардал, төсөл, арга хэмжээний ТХЗ-ын өнөөгийн байдлыг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлт	ТХЗ биелэсэн (4);, Цөөн сорилтууд хэвээр байгаа (8), Зарим сорилтууд хэвээр байгаа (12), Томоохон сорилтууд хэвээр байгаа (16)	16	16
	Зардал, төсөл, арга хэмжээ ТХЗ-ын чиг хандлагыг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлт	Хэвийн хэрэгжиж байгаа (4), Сайжирч байгаа (8), Зогсонги байдалтай байгаа (12), Буурах хандлагатай байгаа (16)	12	12
		Нийт	28	28
4. Байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл	Хэрэгжүүлж буй зардал, төсөл, арга хэмжээ нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх үү? (Жишээ нь, хүлэмжийн хий ялгаруулж байгаа эсэх? тухайн төсөл нь ой модыг устгах эсэх? г.м.)	Сөрөг нөлөөгүй (0), Бага зэргийн сөрөг нөлөөтэй (-5), их хэмжээний сөрөг нөлөөтэй (-10)	-5	0

Нийгэм, хүн амд сөрөг нөлөөлөл үзүүлэх үү? (Жишээ нь, тухайн төсөл хэрэгжсэнээр тухайн бүсэд амьдарч буй хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх эсэх?, орон нутгийн бизнест сөрөг нөлөө үзүүлэх эсэх? г.м.)	Сөрөг нөлөөгүй (0), Бага зэргийн сөрөг нөлөөтэй (-5), их хэмжээний сөрөг нөлөөтэй (-10)	0	0
Эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлэх үү? (Уг төсөл нь жендерийн тэгш бус байдлыг бий болгож байгаа эсэх? Ажилгүйдлийг бий болгож байгаа эсэх? г.м.)	Сөрөг нөлөөгүй (0), Бага зэргийн сөрөг нөлөөтэй (-5), их хэмжээний сөрөг нөлөөтэй (-10)	0	0
	Нийт	-5	0
	Нийт	81	71
	Тэнцсэн/ тэнцээгүй	тэнцсэн	тэнцээгүй

Эх сурвалж: Сангийн Яам, төслийн зөвлөхүүд

7. Зардал, төсөл, арга хэмжээг баталгаажуулах

ТХЗНБ-ын баримт бичигт туссан 10 салбарт хамаарах зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох үйл ажиллагааг гүйцэтгэсний дараа тус зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтыг эцэслэн баталгаажуулах шаардлагатай юм. Энэ нь татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, сонгох үйл ажиллагааны хамгийн эцсийн үе шат юм (Зураг 1, 2-ийг үзэх). ТХЗНБ-ын баримт бичигт татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засгийн газар баталгаажуулахаар тусгасан. Тухайлбал, Сангийн яам сонгогдсон зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтыг эцэслэн гаргаж, холбогдох хууль⁴, журамд нийцүүлсний дараа Засгийн газарт хүргүүлнэ. Засгийн газар ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтыг батална.

Хэрэв Монгол Улсын Засгийн газар ТХЗ-той нийцсэн бондыг олон улсын зах зээлд гаргавал, татан төвлөрүүлсэн хөрөнгийг Засгийн газрын баталсан байгаль орчин, нийгэм, эдийн засагт эерэг нөлөө бүхий зардал төсөл, арга хэмжээнд хуваарилна. Цаашид Засгийн газар нь зардал, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хүрэх үр дүнгийн биелэлт, байгаль, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар жил бүр тайланг гаргаж, олон нийт болон хөрөнгө оруулагч нарт ил тод мэдээлэх үүргийг хүлээнэ.

Зардал, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хүрэх үр дүнгийн биелэлт, байгаль, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн жилийн тайланг хэрхэн бэлтгэх аргачлалыг энэ гарын авлагаас тусад нь боловсруулах болно.

Дүгнэлт

Сангийн яамнаас Монгол Улсын “Тогтвортой Хөгжлийн Зорилгуудтай Нийцсэн Бонд (ТХЗНБ)”-ын баримт бичгийг 2023 онд гаргасан. Уг баримт бичгийн “Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт”, “Зардлыг үнэлэх, сонгох” гэсэн хэсгүүдийг хэрхэн хийж гүйцэтгэх дэлгэрэнгүй аргачлалыг тус гарын авлагаар боловсруулав.

ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээг тодорхойлох, үнэлэх, сонгох гарын авлагыг “ТХЗ-той төсвийн зарлагыг холбох”, “ТХЗ-той холбогдсон зарлагыг Бондын шалгуур үзүүлэлттэй уялдуулах”, “Хориглох үйл ажиллагааны жагсаалттай тулгах”, “Зардал, төсөл, арга

⁴ Өрийн удирдлагын тухай хууль болон бусад хууль, журам

хэмжээний санал хүргүүлэх (дэлгэрэнгүй жагсаалт)”, “Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох (хураангуй жагсаалт)”, “Зардал, төсөл, арга хэмжээг баталгаажуулах” гэсэн 6 үе шаттай байхаар бэлтгэсэн.

ТХЗ-той төсвийн зарлагыг холбох аргачлалыг тусдаа гарын авлагын дагуу хийж гүйцэтгэсэн. Тус гарын авлага нь ТХЗНБ-ын татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох ажлын эхний үе шат болно. ТХЗ-той төсвийн зарлагыг холбох аргачлалыг тусгайлан боловсруулж, улмаар холбох ажлыг ТХЗНБ-ын баримт бичигт туссан салбар, яамдын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Тухайлбал, Монгол Улсын хувьд анх удаагаа ТХЗНБ-ын баримт бичигт туссан 10 салбар, 9 яамны хүрээнд ТХЗ-ыг 2023 оны улсын төсвийн зарлагатай холбосон.

ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлтийг хангах зардал, төсөл арга хэмжээ нь Монгол Улсын 2023 оны төсөвт туссан зардал, төсөл, арга хэмжээгээр хязгаарлагдахгүй, илүү өргөн цар хүрээтэй зардал, төсөл, арга хэмжээг хамарна. Тухайлбал, Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж байгаа зардал, төсөл, арга хэмжээг ТХЗ-ын зорилттой холбоогүй. Цаашид ТХЗНБ-той уялдсан зардал, төсөл, арга хэмжээний нэмэлт жагсаалтыг салбарын яамд болон Сангийн яам гаргах шаардлага тавигдаж байна.

Хоёр дахь үе шатанд ТХЗ-той төсвийн зарлагыг холбосны дараа бэлэн болсон зардлын жагсаалтыг ТХЗНБ-ын баримт бичигт туссан 10 салбарын шалгуур үзүүлэлт тус бүрд тусгай код өгсөн. Уг кодоор холбогдох зардал, төсөл, арга хэмжээг ангилан, уялдуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Дараагийн шатанд ТХЗНБ-ын баримт бичигт туссан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтыг Хориглох үйл ажиллагааны жагсаалттай нэг бүрчлэн тулгалт хийсэн. Хориглох үйл ажиллагааны жагсаалтад эрчим хүчний салбарын зардал, төсөл, арга хэмжээ ихэвчлэн хамрагдсан.

Дөрөв дэх шатанд Салбарын яам нь төслийн саналыг Бондын шалгуур үзүүлэлт болон Бондын хориглох үйл ажиллагааг хангаж буй зардал, төсөл, арга хэмжээний жагсаалтад үндэслэн бэлтгэсэн. ТХЗНБ-ын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний саналыг гаргахдаа Бондын шаардлагуудыг бүрэн хангаж буй зардал, төсөл, арга хэмжээнээс зайлшгүй шаардлагатай, тухайн салбарын тэргүүлэх чиглэлтэй уялдсан, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой төслийг сонгон авч, саналаа Сангийн яаманд хүргүүлэхээр гарын авлагад тусгасан.

Дараагийн шатанд ТХЗНБ-оор санхүүжих зардал, төсөл, арга хэмжээний үр шим хүртэгчийн тоог тодорхойлж, нэг сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчийн тоон үзүүлэлтээр зардал, төсөл, арга хэмжээг үнэлсэн. Салбар бүрд, зардал, төсөл, арга хэмжээ бүрд үр шим хүртэгч нь харилцан адилгүй өөр байна.

Зарим салбарын зардал төсөл арга хэмжээний үр шим хүртэгчийг тодорхойлоход хүндрэлтэй байна. Нийгмийн салбарын үр шим хүртэгч нь төсвийн төлөвлөлт хийхэд шууд ашиглагддаг тул үр шим хүртэгчийг тодорхойлоход илүү хялбар байна. Харин хөдөө аж ахуй, байгаль орчны салбарын үр шим хүртэгч нь төсвийн төлөвлөлт хийхэд ашиглагддаггүй тул холбогдох үр шим хүртэгчийн мэдээллийг олоход хүндрэлтэй байна. Тухайлбал, мал эмнэлгийн вакцины зардлыг тооцохдоо малын тоог вакцины нэгж үнээр нь үржүүлэн гаргадаг. Харин эцсийн үр шим хүртэгч нь тухайн малын эзэд буюу малчид юм. Гэтэл малаа вакцинд хамруулсан малчдын тоон мэдээллийг олох боломж хомс байна. Соёлын салбарын хувьд үр шим хүртэгч (музей, номын сан, театраар үйлчлүүлсэн хүн) нь тодорхой боловч төсвийн байгууллага, засаг захиргааны нэгжээр нарийвчлан гаргасан статистик мэдээлэл олдохгүй байна. Цаашид,

салбарын яамд болон Сангийн яам төсвийн төсөл боловсруулахдаа үр шим хүртэгчийг тодорхойлж, мэдээллийг төсвийн төсөл боловсруулахдаа цуглуулах шаардлагатай байна.

1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоон үзүүлэлтийг тооцож оноо өгөхөд харьцуулах жишиг үзүүлэлт (benchmark) байхгүй байна. Зардал, төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгохдоо 1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоон үзүүлэлтийг үнэлж оноо өгөхдөө үнэлгээ хийж буй хүний субъектив байдлыг багасгах зорилгоор “персентил” статистик аргыг ашигласан. Тухайн салбарын 1 сая төгрөгт ноогдох үр шим хүртэгчдийн тоог персентил ашиглан эрэмбэлж зардал, төсөл, арга хэмжээг сонгох аргачлалыг боловсруулсан.

НҮБ-ын гишүүн 193 улс 2015 онд ТХЗ-ыг баталснаас хойш жил бүр гарсан ахиц дэвшлээ “Тогтвортой Хөгжлийн Тайлан”-аар тайлагнадаг. ТХЗНБ-ын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн түвшнийг ТХЗ-ын өнөөгийн байдал болон ТХЗ-ын чиг хандлага гэсэн 2 бүрэлдэхүүн хэсэгт хуваан зардал, төсөл, арга хэмжээг үнэлсэн.
